

"ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК-ИЙН

2024 ОНЫ ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Тус компанийн 2024 оны дотоод аудитын календарчилсан төлөвлөгөөг 01 дүгээр сарын 05-ны өдөр батлуулсаны дагуу дараах ажил хийгдсэн байна.

1. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих ажлын хүрээнд Гүйцэтгэх захирал болон Захиргаа удирдлагын хэлтсээс гаргасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой 36 удаагийн А тушаал, 103 удаагийн Б тушаалаар баталсан журам, шийдвэрийн агуулгад хууль, тогтоомжийн нийцлийн аудитыг тавьж ажиллажээ.
2. Албан хаагчдын ажлын байран дахь ёс зүйн дүрмийн хэм хэмжээ, шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан ба иргэд, үйлчлүүлэгч байгууллагаас ажиллагсадтай холбоотой гомдол, санал гараагүй байна.
3. Байгууллагын санхүү үйл ажиллагаа, шилэн дансны хөтлөлтөд хуулийн дагуу хяналт тавьж ажилласан. Үндэсний аудитын газраас 2023 оны санхүүгийн тайланд хийсэн шалгалтаар 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн ба үүний дагуу хийсэн ажлыг дэлгэрэнгүй тайланг хавсаргав.
4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулан батлуулж, хэрэгжүүлж байна.
5. ТУЗ-ийн баталсан компанийн 2024 оны зорилтод түвшинд тусгасаны дагуу Бараа, ажил үйлчилгээ авахаар 13 тендер зарлаж 10 сонгон шалгаруулалт амжилттай болсон ба 510.7 сая төгрөгийн худалдан авалт хийж, 1 тендерийн гэрээ хийгдээгүй байна. /Тодорхой шалтгаанаар 3 тендер амжилтгүй, 8 тендер зарлагдаагүй байгааг 2025 оны зорилтот түвшинд тусгасан./ Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 16 удаагийн 278,2 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна. Тендерийн болон шууд худалдан авалттай холбоотой гомдол гараагүй болно.
6. Хэлтэс, нэгжүүдийн 2023 оны ажлын тайланг Гүйцэтгэх захирлын хурлаар хэлэлцүүлсэн.
7. Компанийн эд хөрөнгийн тооллогыг журмын дагуу зохион байгуулж, тайлан гаргасан.

Үндэсний аудитын газраас хийсэн аудитын
шалгалтын хүрээнд хийсэн ажлууд

Тус компанийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын газраас аудит хийж 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн. Илэрсэн зөрчил, авсан арга хэмжээг дурдвал:

1. Орон нутагт томилолтоор ажилласан ажилчдад албан томилолтын хугацаанд 5.9 сая төгрөгийн хоол унааны мөнгө давхардуулан олгосон зөрчилд Улсын төсөвд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

Авсан арга хэмжээ: Төлбөрийн актад дурдагсан 5,916,000 төгрөгийг ажилчдаас буцаан төвлөрүүлж, 2024 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Улсын төсвийн Аудитын шалгалтын орлогын Төрийн сан банкны 100900000601 тоот дансанд шилжүүлсэн.

2. Байгууллагаас авах 392.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчилд “Авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгах тухай” албан шаардлага өгсөн.

Авсан арга хэмжээ: Хавсралт: 1-ээр дэлгэрэнгүй тайлбар хүргүүлэв.

3. Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/89 тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогы баримт бичгийг /НБББББ/ мөрдөж байгаа ба шинэчлэгдсэн стандарт, хууль, дүрэм, журамд нийцүүлэн өөрчлөлтийг тухай бүрт нь тусгаагүй зөрчилд НБББББ-ийг өөрсдийн нөөц бололцоогоор сайжруулалт хийх зөвлөмж өгсөн.

Авсан арга хэмжээ: Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу Санхүүгийн хэлтэстэй хамтран НБББББ-г Гүйцэтгэх захирлаар батлуулан ажиллаж байна.

4. Компанийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй, Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-ыг 2012 онд үүсгэн байгуулахад эхэлтийн балансад тусгасан Эгийн голын УЦС барих төслийн хүрээнд хэрэгжсэн 1152-MON(SF) тоот Эгийн голын УЦС барих дамжуулан зээлдүүлэх гэрээний 3,731.9 сая төгрөгийн өр, Эгийн голын УЦС-ын Техник эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төслийн судалгааны 46 боть хэвлэмэл материалыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлээгүй

зөрчилд эрх бүхий байгууллагад хандаж урт хугацаат зээлийн асуудлыг шийдвэрлэх зөвлөмж өгсөн.

Авсан арга хэмжээ: Хавсралт: 2-оор дэлгэрэнгүй тайлбар хүргүүлэв.

Хавсралт 1.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ГАЗРААС ШИЛЖИЖ ИРСЭН

НАЙДВАРГҮЙ АВЛАГЫН ТАЛААР ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын засгийн газрын 2012 оны 8 дугаар сарын 27-ний өдрийн 6 дугаар тогтоолоор Эрчим хүчний газар татан буугдаж, 2012 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ байгуулагдсан. Эрчим хүчний газрын санхүүгийн тайланд байсан 665,579,443,15 /Зургаан зуун жаран таван сая таван зуун далан есөн мянга дөрвөн зуун дөчин гурван мянган төгрөг арван таван мөнгө/ төгрөгийн авлага “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын балансаас балансад шилжиж ирсэн.

Нийт 33 ААН, 5 хувь хүмүүсийн нийт 595,9 сая төгрөгийн дүнтэй авлагууд 1207 тоот авлагын дансанд анх бүртгэгдсэн ба анхан шатны материалын бүртгэлгүй буюу гэрээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, хэзээ хэрхэн үүссэн журналын бичилтгүй тул баримтын бүрдэл хангагдахгүй гэдэг шалтгаанаар шүүхэд өгөх боломжгүй 592,733,616.85 төгрөгийн үлдэгдэлтэй хэвээр 2012-2020 онуудын жилийн эцсийн санхүүгийн тайлангуудад тусгагдсан.

Эдгээр авлагуудыг тодруулах үүднээс удаа дараа ажлын хэсэг байгуулан ажилласан. Тухайлбал Улсын бүртгэлийн ерөнхий газраас лавлагаа авсан, Эрчим хүчний яамны архивын материалуудтай танилцаж тодруулсан, харьяа үйлдвэрийн газрууд болон хаяг нь тодорхой бүх ААН рүү албан бичгээр хандаж тодруулсан.

Үүнд:

1. Харьяа үйлдвэрүүд болох 10 байгууллага санхүүгийн тайланд ийм өр төлбөр бүртгэгдээгүй байна гээд хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ албан бичгээр хариу өгсөн. Нийт - 53,248,694.87 /Тавин гурван сая хоёр зуун дөчин найман мянга зургаан зуун ерэн дөрвөн төгрөг наян долоон мөнгө/ төгрөгийн авлага
2. Улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлгүй 11 байгууллагын нийт 387,277,793.13 /Гурван зуун наян долоон сая хоёр зуун далан долоон

мянга долоон зуун ерэн гурван төгрөг арван гурван мөнгө/ төгрөгийн авлага

3. Улсын бүртгэлийн мэдээллийн сангаас татан буугдсан 1 байгууллагын 64,000.00 /Жаран дөрвөн мянган/ төгрөгийн авлага
4. Албан бичгээр хандсан боловч хариу тайлбар ирүүлдэггүй 8 байгууллагын 111,748,154.87 /Нэг зуун арван нэгэн сая долоон зуун дөчин найман мянга нэг зуун тавин дөрвөн төгрөг наян долоон мөнгө/ төгрөгийн авлага
5. Нэр, хаяг тодорхойгүй 2 байгууллагын 467,485.38 /Дөрвөн зуун жаран долоон мянга дөрвөн зуун наян таван төгрөг гучин найм/ төгрөгийн авлага,
6. Регистрийн дугаар, холбоо барих боломжгүй 5 хувь хүний 39,927,128.79 /Гучин есөн сая есөн зуун хорин долоон мянга нэг зуун хорин найман төгрөг далан есөн мөнгө/ төгрөгийн авлага

Шүүхэд хандахад тухайн байгууллага, хувь хүнийг өртэй гэдгийг нотлох баримт хангалтгүй гэдгээр /гэрээгүй, тооцоо нийлсэн актгүй/ хүлээж авдаггүй .

Иймд эдгээрийг Найдваргүй авлагад тооцсон бөгөөд 2017 онд 200.0 сая төгрөгөөр найдваргүй авлагын нөөцийг байгуулсан хэдий ч төлбөрийг барагдуулах этгээдийн *төлж чадахгүйг* нотлох шүүхийн шийдвэргүйгээс авлагаас хасаагүй байсан.

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 318 дугаар тогтоолоор “Эрчим хүчний хөгжлийн төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар болон “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрыг нийлүүлэн “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулахад ТӨБЗГ-н тогтоолоор 200,0 сая төгрөгийн найдваргүй авлагыг эхлэлийн баланс дээр хассан ба одоогийн байдлаар “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-н балансад Эрчим хүчний газрын үлдэгдэл авлага 392,7 сая төгрөг байна.

1201-00-00-000-00-00-014 ЭХГ-ын үлдэгдэл авлага		
1231	ЭХЗасварын үйлдвэр	142,308,049.39
1232	ДУЦС-н ТХН	14,790,554.00
1233	Бөх мөрөн НХЦСтанц	162,693,100.91

1234	Бурбодстрой ХХК	4,844,443.75
1235	Монросцветмет нэгдэл	14,745,444.00
1236	Үүрэг трейд ХХК	28,798,915.30
1237	Халамж ХХК	10,838,077.00
1238	Чандмань ХХК	13,715,032.50
Дансны дүн		392,733,616.85

Хавсралт 2.

Эгийн голын дамжуулан зээлдүүлэх гэрээний тухай

Азийн хөгжлийн банк болон Монгол банкны хооронд 1992 онд Эгийн голын усан цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төслийн судалгааг хийхээр 2.75 сая зээлжих тусгай эрх буюу 3.8 сая ам.долларын дүнтэй 1152-MON (SF) дугаар бүхий зээлийн гэрээг байгуулсан ба 2006 онд дамжуулан зээлдүүлэх гэрээ болгон Сангийн яам болон Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв ТӨААТУҮГ-тай байгуулсан байна .

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТУГ 2012 онд үүсгэн байгуулагдахад эхлэлтийн баланс дээр 1152-MON(SF) тоот Эгийн голын УЦС барих Дамжуулан зээлдүүлэх гэрээний зээл 3,731,110,140 төгрөгийн дүнтэйгээр Урт хугацаат зээл дансанд, хөрөнгө талдаа Үндсэн хөрөнгийн Дуусаагүй барилга дансанд балансаас балансад шилжиж ирсэн. Тухайн зээлийн санхүүжилтаар хийгдсэн Эгийн голын усан цахилгаан станцын Техник эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төслийн судалгааны 46 боть хэвлэмэл материал хадгалагдаж байна.

Эгийн голын УЦС барих 1152-MON(SF) тоот зээлийг шилжүүлэх хүсэлтийг Эрчим хүчний яам руу 2015 оны 5 дугаар сарын 19 –ны өдрийн 1/478 тоот, 2017 оны 1 дүгээр сарын 24 –ны өдрийн 1/127 тоот, 2017 оны 6 дугаар сарын 15 –ны өдрийн 1/523 тоот, ТӨБЗГ руу 2017 оны 4 дүгээр сарын 25 –ны өдрийн 1/377 тоот, Сангийн яам руу 2017 оны 5 дугаар сарын 31–ны өдрийн 1/482 тоот, 2018 оны 4 дүгээр сарын 10 –ны өдрийн 1/374 тоот албан бичгээр тус тус явуулсан хэдий ч одоо болтол шийдвэрлэгдээгүй байна.

ТӨБЗГ-ын хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай 2017 оны 6-р сарын 13-ны өдрийн №290-р тогтоол болон 2017 оны санхүүгийн тайланд хийсэн Үндэсний аудитын газрын зөвлөмжид Эгийн голын УЦС барих Урт хугацаат зээлийн эх үүсвэрийг зарцуулсан хөрөнгө оруулалт болох 3,731,110,140 төгрөгийн дүнтэй “Дуусаагүй барилга” нь ЭХХТ-ийн дансанд бүртгэлтэй байгаа нь НББ тухай хуулийн 4.1.1, СТОУС, Санхүүгийн тайлагналын суурь үзэл баримтлалын 4.44 дагуу “Хөрөнгө нь аж ахуйн нэгжид эдийн засгийн ирээдүйн өр өгөөжийг авч ирэх магадлалтай бөгөөд түүний өртөг үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой бол балансад тусгахаар хүлээн зөвшөөрнө” гэж заасныг зөрчсөн байна гэж үзсэн.

1152-MON(SF) тоот урт хугацаат зээлийг Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ний өдрийн хуралдааны шийдвэрээр байгуулагдсан “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХК-д шилжүүлэх асуудал дээр дээд шатны байгууллагуудын шийдвэрийг хүлээж байна.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР-т

Хөрөнгө шилжүүлэх тухай

Азийн хөгжлийн банк болон Монгол банкны хооронд 1992 онд Эгийн голын усан цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төслийн судалгааг хийхээр 2.75 сая зээлжих тусгай эрх буюу 3.8 сая ам.долларын дүнтэй 1152-MON (SF) дугаар бүхий зээлийн гэрээг байгуулсан ба 2006 онд дамжуулан зээлдүүлэх гэрээ болгон Сангийн яам болон Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв ТӨААТУҮГ-тай байгуулсан байна .

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТУҮГ 2012 онд үүсгэн байгуулагдахад эхлэлтийн баланс дээр 1152-MON(SF) тоот Эгийн голын УЦС барих Дамжуулан зээлдүүлэх гэрээний зээл 3,731,110,140 төгрөгийн дүнтэйгээр Урт хугацаат зээл дансанд, хөрөнгө талдаа Үндсэн хөрөнгийн Дуусаагүй барилга дансанд балансаас балансад шилжиж ирсэн. Тухайн зээлийн санхүүжилтаар хийгдсэн Эгийн голын усан цахилгаан станцын Техник эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төслийн судалгааны 46 боть хэвлэмэл материал хадгалагдаж байна.

ТӨБЗГ-ын хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай 2017 оны 6-р сарын 13-ны өдрийн №290-р тогтоол болон 2017 оны санхүүгийн тайланд хийсэн Үндэсний аудитын газрын зөвлөмжид Эгийн голын УЦС барих Урт хугацаат зээлийн эх үүсвэрийг зарцуулсан хөрөнгө оруулалт болох 3,731,110,140 төгрөгийн дүнтэй “Дуусаагүй барилга” нь ЭХХТ-ийн дансанд бүртгэлтэй байгаа нь НББ тухай хуулийн 4.1.1, СТОУС, Санхүүгийн тайлагналын суурь үзэл баримтлалын 4.44 дагуу “Хөрөнгө нь аж ахуйн нэгжид эдийн засгийн ирээдүйн өр өгөөжийг авч ирэх

магадлалтай бөгөөд түүний өртөг үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой бол балансад тусгахаар хүлээн зөвшөөрнө” гэж заасныг зөрчсөн байна гэж үзсэн.

Мөн тус компанийн Үндэсний аудитын газраас 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланд энэ асуудлыг “Компанийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй, Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-ыг 2012 онд үүсгэн байгуулахад эхэлтийн балансад тусгасан Эгийн голын УЦС барих төслийн хүрээнд хэрэгжсэн 1152-MON(SF) тоот Эгийн голын УЦС барих дамжуулан зээлдүүлэх гэрээний 3,731.9 сая төгрөгийн өр, Эгийн голын УЦС-ын Техник эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төслийн судалгааны 46 боть хэвлэмэл материалыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлээгүй зөрчил”-д эрх бүхий байгууллагад хандаж урт хугацаат зээлийн асуудлыг шийдвэрлэх зөвлөмж өгсөн.

Эгийн голын УЦС барих 1152-MON(SF) тоот зээлийг шилжүүлэх хүсэлтийг Эрчим хүчний яам руу 2015 оны 5 дугаар сарын 19 –ны өдрийн 1/478 тоот, 2017 оны 1 дүгээр сарын 24 –ны өдрийн 1/127 тоот, 2017 оны 6 дугаар сарын 15 –ны өдрийн 1/523 тоот, ТӨБЗГ руу 2017 оны 4 дүгээр сарын 25 –ны өдрийн 1/377 тоот, Сангийн яам руу 2017 оны 5 дугаар сарын 31–ны өдрийн 1/482 тоот, 2018 оны 4 дүгээр сарын 10 –ны өдрийн 1/374 тоот албан бичгээр тус тус хандсан хэдий ч одоо болтол шийдвэрлэгдээгүй байна.

Иймд 1152-MON(SF) тоот урт хугацаат зээлийг Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ний өдрийн хуралдааны шийдвэрээр байгуулагдсан “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХК-д шилжүүлэх асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэж өгнө үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.БЯМБАСҮРЭН